



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Удирдлагын академийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 5 нэрийн 11,065,980.00 (арван нэгэн сая жаран таван мянга есөн зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Удирдлагын академийн захирал С.Зулпхард дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000121

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 04
дүгээр сарын 14-ны өдрийн 168
дугаар тогтоолын хавсралт

**УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ АКТАЛЖ,
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тоос сорогч	2016-11-30	ш	1	369,990.00	369,990.00	369,990.00	0.00
2	Сирень дохиололын төхөөрөмж	2012-03-31	ш	1	3,267,000.00	3,267,000.00	3,267,000.00	0.00
3	Угаалгын машин	2014-08-31	ш	1	329,990.00	329,990.00	329,990.00	0.00
4	Цаас устгач	2017-01-31	ш	1	299,000.00	299,000.00	299,000.00	0.00
5	Дулааны төв тоолуур	2016-09-23		1	6,800,000.00	6,800,000.00	6,800,000.00	0.00
				5		11,065,980.00	11,065,980.00	0.00
	Нийт хөрөнгийн дүн			5 (тав)		11,065,980.00 (арван нэгэн сая жаран таван мянга есөн зуун ная)	11,065,980.00 (арван нэгэн сая жаран таван мянга есөн зуун ная)	